**БАТЛАВ:** ХАБҮЛЛ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.АМАР

# СОРИЛТЫН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ХӨТӨЛБӨР

**/ 2023 оны II ээлж /**

**Хамрах хүрээ:** Үндэсний түвшинд итгэмжлэгдсэн төрийн, хувийн өмчит, СХЗГ-ын харьяа орон нутгийн сорилтын лабораториудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эмийн үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хими, нян судлалын лабораториуд хамарна.

**Хөтөлбөрийн зорилго:** Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын хими, микробиологийн хяналтын чиглэлээр шинжилгээний үр дүнгийн үнэн зөвийг хянах, шинжилгээний дүнгийн нэгдмэл байдал, хэмжлийн нарийвчлалыг шалгах, гадаад хяналтыг зохион байгуулснаар оролцогч лабораториудын шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

**Хөтөлбөр зохион байгуулах чиглэл:** Ур чадварын үнэлгээг:

**Хими** - Усанд хүнд металл **цайрын агуулыг мг/кг ppm** багажит шинжилгээний аргаар, жүүсэнд **хүчиллэг % ;** уламжлалт шинжилгээний аргаар, элсэн чихэрт **сахарозын агуулга %** багажит шинжилгээний аргаар тодорхойлох;

**Нян судлал**- Шингэн, хуурай хүнсний бүтээгдэхүүн / жүүс, жимсний нухаш /, ариутгасан шингэн сүү, хиам, элэгний нухаш, бусад хүнс, шингэн тэжээлт орчин **халдварлуулсан нян**, өтгөрүүсэн сүү **хогц моогонцор**, усан уусмал **нянгийн ерөнхий тоог** тоолох;

**Хөтөлбөр хэрэгжих хугацаа:** Эхний үе шат 2023 оны 09 сарын 18-ны өдрөөс 11 сарын 10–ны өдөр хүртэл

**Хөтөлбөрийн тайлан:** Сорилтын үр дүнгийн тайланг нэгтгэн боловсруулалт хийж оролцогч лабораториудад 2023 оны 11 сарын 20-ны дотор хураангүйгаар, дэлгэрэнгүй тайланг Үндэсний итгэмжлэлийн төв, СХЗГ-т хүргүүлэх, ХАБҮЛЛ-ийн nrl.gov.mn цахим хаягт байршуулах;

**Хөтөлбөрийн чиглэл**

| № | Хөтөлбөрийн чиглэл | | | Дээж | Үзүүлэлт | Шинжилгээний аргын стандарт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ур чадварын сорилтын лаборатори | Хүнсний химийн шинжилгээ | Багажит шинжилгээний арга | Усанд хүнд металл агуулга | **Цайрын агуулыг** тодорхойлох мг/кг ppm; | **Хүнсний бүтээгдэхүүнд цайрын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга : MNS GB 5009 -14:2021** |
| | | | | Элсэн чихэр | **Сахарозын агуулга** тодорхойлох % | **Элсэн чихрийн шинжилгээний арга: MNS 1752:1973** |
| | | | Уламжлалт шинжилгээний арга | Жүүс | **Хүчиллэг** тодорхойлох %; | **Бүх төрлийн ундаа жүүсэнд хүчиллэг тодорхойлох арга MNS 5321:2016** |
| 2 | | Микробиологийн шинжилгээ | | Шингэн болон хатуу хүнс, шингэн тэжээлт орчин, | Бактерийн стандарт өсгөвөр тодорхойлох; | **Микробиологи-Микробиологийн шинжилгээний ерөнхий заавар.**<br>**MNS ISO 7218:1996** |
| | | | | Өтгөрүүсэн сүү | Хөгц мөөгөнцрийн стандарт өсгөвөр тодоройлох; | **Хүнсний бүтээгдэхүүн Хөгц мөөгөнцар тодорхойлох шинжилгээний арга MNS 5132:2002** |
| | | | | Усан уусмал | Бактерийн стандарт өсгөврийн тоог тоолох; | **Микробиологи $30^0$С-т ургасан бичил биетний колони тоолох ерөнхий арга MNS ISO 4833:95** |

**ХАБҮЛЛ-ийн СТЭҮТов**